

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/119/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Дорноговь аймаг 2021 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Аудитор: Т.Мөнхтогтох Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон улсын стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДГА	Дорноговь аймаг
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6.Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1.Ерөнхий зүйл	14
3.2.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	14
3.4.Материаллаг байдал	15
3.5.Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7.Шилэн дансны мэдээлэл	17
3.8.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9.Аудитын илрүүлэлт	17
Залруулсан алдаа	17
Аудитын зөвлөмж	18
3.10.Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4.Менежментийн захидал	18
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.22 № 1-6/77

танай _____-ны № _____-г

ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ
СУМ ДУНДЫН ЦАГДААГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА, ЦАГДААГИЙН
ХОШУУЦ Ц.ЭХБААТАР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тухай, үйл ажиллагааны тайлангийн тухай, бусад адилтгах тайлангийн талаар төсвийн захирагчид анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>88,015,652.16</u>	<u>107,495,609.96</u>
33	АВЛАГА	1,999,394.26	739,798.13
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,999,394.26	739,798.13
35	БАРАА МАТЕРИАЛ	86,016,257.90	106,755,811.83
351	Түүхий эд материал	42,721,652.85	59,308,966.68
35110	Тусгай зориулалттай материал	42,027,956.95	58,634,270.38
35130	Эм боох материал	693,695.90	674,696.30
354	Хангамжийн материал	39,473,999.05	43,668,598.15
35410	Бичиг хэргийн материал	10,655,384.00	11,312,908.00
35420	Аж ахуйн материал	7,795,183.89	5,760,114.99
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	501,800.00
35440	Түлш, шатах тослох материал	395,456.66	2,451,306.66
35450	Барилгын засварын материал	3,481,775.00	3,094,360.00
35460	Хүнсний материал	00.00	945,050.00
35470	Бусад хангамжийн материал	17,146,199.50	19,603,058.50
35600	Мал амьтад	3,820,606.00	3,778,247.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,249,658,641.48</u>	<u>1,221,448,597.49</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,249,658,641.48	1,221,448,597.49
392	Биет хөрөнгө	1,102,427,641.48	1,074,270,097.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	958,145,052.98	958,145,052.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	-39,088,306.92	-78,176,613.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	178,080,455.04	220,080,455.04
39204	Хуримтлагдсан элэгдэл	-98,576,022.96	-134,761,637.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	179,751,314.18	227,657,742.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	-87,030,961.94	-126,517,012.57
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,184,460.00	22,184,460.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,355,621.19	-17,467,962.12
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай төхөөрөмж	3,083,951.00	3,083,951.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,100,000.00	2,995,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,761,678.71	-2,953,337.83
393	Биет бус хөрөнгө	147,231,000.00	147,178,500.00
39301	Програм хангамж	00.00	105,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-52,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	147,126,000.00	147,126,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,337,674,293.64</u>	<u>1,328,944,207.45</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,337,674,293.64</u>	<u>1,328,944,207.45</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,337,674,293.64	1,328,944,207.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	450,852,981.23	450,852,981.23
51101	Өмч: - төрийн	450,852,981.23	450,852,981.23
512	Хуримтлагдсан үр дүн	155,415,997.13	146,685,910.94
51210	Өмнөх үеийн үр дүн	182,222,929.70	155,415,997.13
51220	Тайлант үеийн үр дүн	-26,806,932.57	-8,730,086.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	731,405,315.28	731,405,315.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,337,674,293.64</u>	<u>1,328,944,207.45</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	998,576,301.25	1,190,879,469.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,296,901.25	109,329,569.23
120	Нийтлэг татварын бус орлого	101,296,901.25	109,329,569.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,324,450.00	4,027,780.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,324,450.00	2,355,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	1,672,380.00
120009	Бусад орлого	00.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	78,070,203.95	69,906,428.05
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	12,902,247.3	35,395,361.18
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	897,279,400.00	1,081,549,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	891,172,500.00	1,047,958,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	891,172,500.00	1,047,958,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,106,900.00	33,591,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,340,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,766,900.00	13,591,600.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	00.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,025,383,233.82	1,199,609,555.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,025,383,233.82	1,199,609,555.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,023,572,795.00	1,195,401,327.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	751,277,934.96	878,746,490.73
210101	Үндсэн цалин	751,277,934.96	563,567,655.73
210102	Нэмэгдэл	00.00	315,178,835.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,789,272.02	19,994,634.40
210201	Тэтгэврийн даатгал	1,525,638.15	2,085,357.00
210202	Тэтгэмжийн даатгал	272,604.48	245,336.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	145,472.00	189,902.40
210204	Ажилгүйдлийн даатгал	30,949.89	49,068.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,814,607.50	17,424,971.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,030,136.01	45,136,265.00
210301	Гэрэл, цахилгаан	9,802,032.02	9,361,806.00
210302	Түлш, халаалт	33,610,503.99	29,561,665.00
210303	Цэвэр, бохир ус	4,617,600.00	6,212,794.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,545,365.02	72,165,349.15
210401	Бичиг хэрэг	6,087,932.26	8,284,940.00
210402	Тээвэр, шатахуун	31,689,340.00	39,221,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,261,932.76	6,061,798.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,266,160.00	4,432,743.75

210408	Бараа материал акталсны зардал	00.00	13,504,117.40
2105	Нормативт зардал	13,365,067.10	18,570,361.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	325,543.10	931,809.60
210502	Хоол, хүнс	13,005,524.00	17,464,652.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	34,000.00	173,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,831,582.20	21,241,537.50
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	5,187,450.00
210604	Урсгал засвар	39,831,582.20	16,054,087.50
2107	Томилолт, зочны зардал	6,410,600.00	8,908,800.00
210702	Дотоод албан томилолт	6,410,600.00	8,908,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,233,262.00	3,205,318.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	533,050.00	1,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	1,313,194.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	380,000.00
210807	Газрын төлбөр	126,500.00	49,488.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	43,712.00	30,636.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,089,575.69	127,432,571.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,310,000.00	8,684,099.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	535,000.00	632,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,244,575.69	118,116,472.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,810,438.82	4,208,228.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,325,000.00	1,630,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,325,000.00	1,330,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	485,438.82	2,578,228.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	485,438.82	2,578,228.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-26,806,932.57	-8,730,086.19
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-26,806,932.57	-8,730,086.19

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	907,668,850.00	1,083,905,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,389,450.00	2,355,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,389,450.00	2,355,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,389,450.00	2,355,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,389,450.00	2,355,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	897,279,400.00	1,081,549,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	891,172,500.00	1,047,958,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	891,172,500.00	1,047,958,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,106,900.00	33,591,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,340,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,766,900.00	13,591,600.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	00.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	907,668,850.00	1,063,905,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	907,668,850.00	1,063,905,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	905,858,411.18	1,059,697,072.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	753,562,534.41	877,486,894.60
210101	Үндсэн цалин	479,454,735.00	476,046,793.60
210102	Нэмэгдэл	274,107,799.41	401,440,101.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,213,230.01	19,994,634.40
210201	Тэтгэврийн даатгал	81,400.00	00.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,900.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,700.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,000.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,112,230.01	19,994,634.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,801,034.01	45,136,265.00
210301	Гэрэл, цахилгаан	9,572,930.02	9,361,806.00
210302	Түлш, халаалт	33,610,503.99	29,561,665.00
210303	Цэвэр, бохир ус	4,617,600.00	6,212,794.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,167,732.75	55,985,190.00
210401	Бичиг хэрэг	4,687,900.00	7,744,100.00
210402	Тээвэр, шатахуун	28,762,400.00	37,983,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,411,932.76	6,337,298.00

210404	Ном, хэвлэл	00.00	90,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,065,499.99	3,169,992.00
2105	Нормативт зардал	13,510,380.00	16,265,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	149,950.00	150,000.00
210502	Хоол, хүнс	12,721,930.00	15,115,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	638,500.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,942,350.00	21,433,296.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,065,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	4,800,500.00
210604	Урсгал засвар	19,877,350.00	16,632,796.00
2107	Томилолт, зочны зардал	6,410,600.00	8,908,800.00
210702	Дотоод албан томилолт	6,410,600.00	8,908,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,390,050.00	2,174,682.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,733,550.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	1,313,194.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	380,000.00
210807	Газрын төлбөр	126,500.00	49,488.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	860,500.00	12,312,310.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	11,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	860,500.00	1,312,310.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,810,438.82	4,208,228.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,325,000.00	1,630,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,325,000.00	1,330,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	485,438.82	2,578,228.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	485,438.82	2,578,228.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	20,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	20,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	20,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	20,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	20,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-20,000,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	450,852,981.23	731,405,315.28	182,222,929.70	1,364,481,226.21
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	450,852,981.23	731,405,315.28	182,222,929.70	1,364,481,226.21
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-26,806,932.57	-26,806,932.57
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,852,981.23	731,405,315.28	155,415,997.13	1,337,674,293.64
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,852,981.23	731,405,315.28	155,415,997.13	1,337,674,293.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	450,852,981.23	731,405,315.28	155,415,997.13	1,337,674,293.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,730,086.19	-8,730,086.19
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,852,981.23	731,405,315.28	146,685,910.94	1,328,944,207.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,050,268,300.00	1,047,735,472.00	2,532,828.00	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,050,268,300.00	1,047,735,472.00	2,532,828.00	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,048,638,300.00	1,046,105,472.00	2,532,828.00	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	878,611,400.00	877,486,894.60	1,124,505.40	99.9
210101	Үндсэн цалин	477,163,100.00	476,046,793.60	1,116,306.40	99.8
210102	Нэмэгдэл	401,448,300.00	401,440,101.00	8,199.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,399,000.00	19,994,634.40	1,404,365.60	93.4
210205	Эрүүл мэндийн даатгал	21,399,000.00	19,994,634.40	1,404,365.60	93.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,137,200.00	45,136,265.00	935.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	9,362,700.00	9,361,806.00	894.00	100.0
210302	Түлш, халаалт	29,561,700.00	29,561,665.00	35.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	6,212,800.00	6,212,794.00	6.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	54,735,800.00	54,733,590.00	2,210.00	100.0
210401	Бичиг хэрэг	7,744,100.00	7,744,100.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	37,323,800.00	37,323,800.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,339,500.00	6,337,298.00	2,202.00	100.0
210404	Ном, хэвлэл	90,000.00	90,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	660,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,578,400.00	2,578,392.00	8.00	100.0
2105	Нормативт зардал	14,925,000.00	14,925,000.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	150,000.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	13,775,000.00	13,775,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,433,300.00	21,433,296.00	4.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,800,500.00	4,800,500.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	16,632,800.00	16,632,796.00	4.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	8,908,800.00	8,908,800.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	8,908,800.00	8,908,800.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,175,200.00	2,174,682.00	518.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,313,200.00	1,313,194.00	6.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	380,000.00	380,000.00	0.00	100.0

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210807	Газрын төлбөр	50,000.00	49,488.00	512.00	99.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,312,600.00	1,312,310.00	290.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,312,600.00	1,312,310.00	290.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,630,000.00	1,630,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,630,000.00	1,630,000.00	0.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	300,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,330,000.00	1,330,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,050,268,300.00	1,047,735,472.00	2,532,828.00	99.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,047,958,300.00	1,045,380,072.00	2,578,228.00	99.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,047,958,300.00	1,045,380,072.00	2,578,228.00	99.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,310,000.00	2,355,400.00	-45,400.00	102.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,310,000.00	2,355,400.00	-45,400.00	102.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00	33,591,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	33,591,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	33,591,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	1,251,600.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	591,600.00
2105	Нормативт зардал	00.00	1,340,000.00
210502	Хоол, хүнс	00.00	1,340,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	20,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	20,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	11,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	11,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	33,591,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	33,591,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	13,591,600.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Дарга, цагдаагийн хошууч Ц.Эхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд цалингийн урамшуулал, хөрөнгийн устгалын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 02-аас 2021 оны 02 дугаар сарын 05–ны хооронд аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3510/1-86 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”;

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 1,390,201.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 13,902.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон, гүйцэтгэлийн үе шатанд 13,289.4 мянган төгрөгөөр тооцож, баталгаажууллаа.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,809.3 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	1,999.3	739.8	-1,259.5
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	86,016.3	106,755.8	20,739.5
Үндсэн хөрөнгө	1,249,658.6	1,221,448.6	-28,210.0
Нийт хөрөнгө	1,337,674.2	1,328,944.2	-8,730.0
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,337,674.2	1,328,944.2	-8,730.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,337,674.2	1,328,944.2	-8,730.0

Авлага дансны үлдэгдэл 739.8 мянган төгрөг болж буурсан байна. Авлага дансны үлдэгдэлд тухайн албанд ажиллаж байгаад цалин бодож олгосны дараа шилжиж явсан алба хаагчаас авах 291.9 мянган төгрөг, Нийгмийн даатгалын хэлтсээс авах 447.9 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 106,755.8 мянган төгрөг болж 20,739.5 мянган төгрөгөөр өссөн байна. Тодруулбал: Албан хэрэгцээнд зориулж тусгай зориулалттай материалын дансанд хамгаалалтын хувцас хэрэглэл, ковид-19 цар тахалтай холбоотой бусад хангамжийн материалын дансанд хөдөлмөр хамгааллын материал, түлш шатах тослох материалын дансанд шатахууны нөөц бүрдүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,221,448.6 мянган төгрөг болж 28,210.0 мянган төгрөгөөр буурсан бөгөөд шилжүүлсэн болон акталсан хөрөнгө байхгүй, элэгдлээрээ хасагдсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 20,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 69,906.4 мянган төгрөгийн автомашин, тусгай хэрэгслийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,360,483.6 мянган төгрөг болж 22,809.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 192,303.2 мянган төгрөгөөр буюу 19.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогууд байна.

Нийт зардал өмнөх оноос 1,168,070.1 мянган төгрөгөөр буюу 13.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, тээвэр шатахуун, урсгал засварын зардлууд байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,070,448.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,070,448.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 20,180.5 мянган төгрөгөөр бууруулж 1,050,268.3 мянган төгрөгөөр баталсан байна. Тодруулбал: байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардлыг бууруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,050,268.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,047,958.3 мянган төгрөгийг улсын төсвөөс 2,310.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,047,958.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 2,355.4 мянган төгрөг, нийт 1,050,313.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,047,735.5 мянган төгрөгийг зарцуулж 2,578.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,047,735.5 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

2020 онд 2,310.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2,532.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 102 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Эрүүлжүүлэхийн хураамж	2,310.0	2,355.4	45.4	102
Нийт дүн	2,310.0	2,355.4	45.4	102

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 20,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 13,591.6 мянган төгрөг /Замын-Үүд сумын ИТХ, ЗДТГ-аас дохиолол авахад 591.6 мянган төгрөг, “Мал мах” арга хэмжээнд 1,500.0 мянган төгрөг, алба хаагчдын дархлаажуулалтад 10,500.0 мянган төгрөг, аймгийн Онцгой комиссоос 1,000.0 мянган төгрөг/, нийт 33,591.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 660.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 591.6 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 1,340.0 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 20,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 11,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 12 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 229.1 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	229.1	1	229.1	-	-	-
Нийт дүн	1	229.1	1	229.1	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33,215.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 33,215.5 мянган төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

Үүнд:

1. Завсрын аудитаар Санхүүгийн үр дүнгийн тайланд түлш халаалтын зардлаас цэвэр бохир усны зардлыг 1,330.1 мянган төгрөгөөр гүйлгэн зарцуулахдаа бодит зарлагаар тайлагнаагүй байсныг залруулав.
2. Үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгслийн элэгдлийг 31,885.4 мянган төгрөгөөр дутуу тооцсон байсныг залруулав.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Албан хаагчдын ажлыг улирлаар бус сар бүр дүгнэж, Цагдаагийн ерөнхий газрын даргын хүчингүй болсон журмыг үндэслэж ажлын үр дүнгээр цалинг нэмэгдүүлэх, бууруулах байгууллагын даргын тушаал гаргасан байна.

1.2 Эрсдэл:

Холбогдох хууль эрхийн акт зөрчигдөх, албан хаагчдын урамшуулалт цалин илүү, дутуу бодогдох.

1.3 Өгсөн зөвлөмж:

Энэ нь (үнэн зөв байдал) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 “улирлын ажлын үр дүнгээр урамшуулал олгох”, 51.2 “... болон 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар, ... тус тус батална”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Албан хаагчдын сарын ажлын үр дүнг харгалзан улирлаар дүгнэж, тогтоосон хувь хэмжээнд багтаан урамшуулал олгох, урамшуулал олгох тушаал гаргахдаа хүчин төгөлдөр эрх зүйн актыг үндэслэл болгож байх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ирүүлсэн.

2 Удирдлагын дээд болон дотоод хяналт

2.1 Илрүүлэлт:

Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн даргын 2020 оны А/30 дугаар тушаалаар 61 нэр төрлийн 685 ширхэг 13.5 сая төгрөгийн эргэлтийн эд хөрөнгийг данс бүртгэлээс хассан боловч хөрөнгийн устгал хийгээгүй байна

2.2 Эрсдэл:

Холбогдох хууль журам мөрдөгдөхгүй байх, хувьдаа завших.

2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 засаж “сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Байгууллагын данс бүртгэлээс хассан хөрөнгийг акталж, устгал хийх.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Замын-Үүд Сум дундын цагдаагийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02			ДГА-2021/119/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтэс		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Завсрын аудитаар албан хаагчдын ажлыг улирлаар бус сар бүр дүгнэж, ЦЕГ-ын даргын баталсан хүчингүй болсон журмыг үндэслэж ажлын үр дүнгээр цалинг нэмэгдүүлэх, бууруулах байгууллагын даргын тушаал гаргасан байна	-	Зөвлөмж өгөх	Дарга, цагдаагийн дэд хурандаа Ахлах нягтлан бодогч	Ю.Чулуунбаатар Д.Отгончимэг
2	Завсрын аудитаар Түлш халаалтын зардлаас цэвэр бохир усны гүйлгээг хийхдээ бодит зарлагаар тайлагнаагүй байна	1,330.1	Залруулга	Дарга, цагдаагийн дэд хурандаа Ахлах нягтлан бодогч	Ю.Чулуунбаатар Д.Отгончимэг
3	Замын-Үүд сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн даргын 2020 оны А/30 дугаар тушаалаар 61 нэр төрлийн 685 ширхэг 13.5 сая төгрөгийн эргэлтийн эд хөрөнгийг данс бүртгэлээс хассан боловч хөрөнгийн устгал хийгээгүй байна	-	Зөвлөмж өгөх	Дарга, цагдаагийн хошууч Ахлах нягтлан бодогч	Ц.Эхбаатар Д.Отгончимэг
4	Үндсэн хөрөнгийн элэгдлийг шүүж үзэхэд 31.8 сая төгрөгийн 9 ширхэг авто тээврийн хэрэгслийн элэгдлийг дутуу бодуулсан байна	31,885.4	Залруулга	Дарга, цагдаагийн хошууч Ахлах нягтлан бодогч	Ц.Эхбаатар Д.Отгончимэг
ДҮН		33,215.5		-	